

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Б.НАРАНТУЯА*

1-А-40-56 9086331

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар сарын 16

№

Улаанбаатар хот

2017 11 27 155

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх /-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид “Захиалагч” гэх/ түүнийг төлөөлж Эм, эмнэлгийн хэрэгслийн албаны дарга Г.Цэцэнсанаа

Нэгөө талаас: Иргэн М.Уранчимэг нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт 4 хоногийн сургалтыг Дархан, Сэлэнгэ аймагт зохион байгуулахад талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2 Гэрээнд зааснаас бусад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцож бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1.-д заасан ажлыг 2017 оны 11 сарын 19-өдрөөс 2017 оны 11 дугаар сарын 24 -ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

3.1. Гэрээт багшийн ажлын хөлсийг 330 000₮ /гурван зуун гучин мянган төгрөг/ -өөр тогтов.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

4.1. Захиалагч нь гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 27-ны дотор хүлээн авч, дүгнэнэ.

4.2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж гүйцэтгэхийг шаардах.

4.3. Гэрээт багшийн ажлын хөлсийг Голомт банк-ны М.Уранчимэг эзэмшигчтэй 2709312098 дугаар данс руу 2017 оны 11 дугаар сарын 20-ны дотор шилжүүлнэ.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж гүйцэтгэнэ.
- 5.3. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.4. “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт сургалтын өмнө оролцогчдоос мэдлэг сорих шалгалт тестээр авч түвшинг тогтоож, сургалтын дараа дахин шалгалтыг тестээр авч сургалтын чанарыг үнэлнэ.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3 Гэрээг 2 хувь үйлдэж “захиалагч” тал нэг хувийг “гүйцэтгэгч” тал нэг хувийг тус тус хадгална.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ


- 7.1 Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМХТ, Эм, эмнэлгийн хэрэгслийн
албаны дарга

Г.Цэцэнсанаа



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМЯ. ЭЭХҮХ-ийн дарга
М.Уранчимэг
/РД:ЧП64090203/